



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/247

Хэрлэн сум

Ажлын хэсэг байуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.12, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3, 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны Улсын төсвийн төсөлд санал оруулах Батноров сумын Бэрх тосгоны доторх болон далд уурхайн музей хүртэлх 2,8 км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл, төсвийн зохиогчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: С.Лхагвачулуун Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Ш.Ариунболор Аймгийн ерөнхий архитектор

Гишүүн: Х.Баярбаатар Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Лхагвачулуун)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатарт)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ